

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/025/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/188
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД
СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ГАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газраас 2025 оны сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүгд Найрамдах Солонгос Улсад үйлдвэрлэсэн тусгай зориулалтын "Хьюндай Мега трак" 5 тонны автомашиныг 115,000.0 мянган төгрөгөөр, "Хьюндай Майти" 2,5 тонн автомашиныг 105,000.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоон тухай" 01/346 дугаар зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 649,708.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг 3 жилээр, балансын үнийг 638,690.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт бүхий нийт 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 82

4126020172

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хувиар үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,509,260.00	4,041,964.39
33	АВЛАГА	-	128,664.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	128,664.39
35	БАРАА МАТЕРИАЛ	4,509,260.00	3,913,300.00
354	Хангамжийн материал	4,509,260.00	3,913,300.00
35410	Бичиг хэргийн материал	2,449,260.00	2,243,300.00
35420	Аж ахуйн материал	810,000.00	580,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,250,000.00	1,090,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,416,726,483.43	5,207,603,468.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,416,726,483.43	5,207,603,468.34
392	Биет хөрөнгө	2,436,390,483.43	3,227,267,468.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,284,578,972.15	3,541,970,201.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,359,861,433.23)	(1,261,152,651.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	840,476,073.00	941,411,073.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(501,294,389.27)	(159,546,051.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,430,519.54	52,411,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,968,266.39)	(12,160,365.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,299,614.80	94,588,814.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,278,873.39)	(43,620,119.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	56,918,608.00	56,918,608.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,195,322.54)	(20,461,298.46)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,499,100.00	10,499,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,131,668.40	73,131,668.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,345,787.64)	(46,723,010.52)
393	Биет бус хөрөнгө	1,980,336,000.00	1,980,336,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,980,336,000.00	1,980,336,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,421,235,743.43	5,211,645,432.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	479,024.00	4,861,950.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	479,024.00	4,861,950.00
413	Өглөг	479,024.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	284,024.00	-
4136	Бусад өглөг	195,000.00	4,861,950.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,861,950.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	195,000.00	-
51	Засгийн газрын хувь оролцоо	4,420,756,719.43	5,206,783,482.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,378,790,604.74	2,378,790,604.74
51101	Өмч: - төрийн	2,378,790,604.74	2,378,790,604.74
512	Хуримтлагдсан үр дүн	1,391,079,789.17	2,336,809,544.71

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	1,391,079,789.17	1,550,782,781.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	786,026,763.30
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	650,886,325.52	491,183,333.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,421,235,743.43	5,211,645,432.73

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,360,304,668.20	3,046,986,288.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,877,409,468.20	1,163,139,288.46
120	Нийтлэг татварын бус орлого	1,877,409,468.20	1,163,139,288.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,877,409,468.20	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,877,409,468.20	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,149,062,988.46
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	14,076,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,482,895,200.00	1,883,847,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,482,895,200.00	1,883,847,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,482,895,200.00	1,883,847,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,863,123,186.03	2,260,959,525.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,863,123,186.03	2,260,959,525.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,862,358,185.79	2,209,802,151.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,087,275,128.00
210101	Үндсэн цалин	-	591,955,258.00
210102	Нэмэгдэл	-	303,939,847.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	98,950,000.00
210104	Урамшуулал	-	92,430,023.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,485,457.95	14,430,861.40
210301	Гэрэл, цахилгаан	4,175,132.92	5,640,501.40
210302	Түлш, халаалт	10,310,325.03	7,440,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,350,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	79,004,830.00
210401	Бичиг хэрэг	-	3,742,470.00
210402	Тээвэр, шатахуун	-	45,988,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,042,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	14,076,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	14,155,200.00
2105	Нормативт зардал	-	9,531,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,531,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	101,684,105.00
210604	Урсгал засвар	-	101,684,105.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,427,680,469.81	519,216,528.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,427,680,469.81	519,216,528.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,192,258.03	398,659,647.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,623,696.00	21,680,944.38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	384,568,562.03	376,978,703.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	765,000.24	51,157,373.96

**Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,936,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,236,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	765,000.24	27,221,073.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	765,000.24	27,221,073.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,497,181,482.17	786,026,763.30
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	548,775,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	548,775,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(548,775,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	948,406,482.17	786,026,763.30

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,482,895,200.00	1,883,847,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,482,895,200.00	1,883,847,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,482,895,200.00	1,883,847,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,482,895,200.00	1,883,847,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,479,219,700.00	1,865,054,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,479,219,700.00	1,865,054,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,478,454,699.76	1,817,596,926.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,385,457.95	14,430,861.40
210301	Гэрэл, цахилгаан	4,175,132.92	5,640,501.40
210302	Түлш, халаалт	10,310,325.03	7,440,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,900,000.00	1,350,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,426,445,741.81	1,633,362,605.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,426,445,741.81	1,633,362,605.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,623,500.00	169,803,459.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,623,500.00	169,803,459.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	765,000.24	47,457,373.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	20,236,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,236,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	765,000.24	27,221,073.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	765,000.24	27,221,073.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,675,500.00	18,792,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,675,500.00	18,792,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,675,500.00	18,792,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,675,500.00	18,792,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,675,500.00	18,792,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,675,500.00)	(18,792,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	653,790,515.03	675,586,179.51	3,708,167,299.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,378,790,604.74	653,790,515.03	675,586,179.51	3,708,167,299.28
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(232,205,430.51)	(232,205,430.51)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	650,886,325.52	1,391,079,789.17	4,420,756,719.43
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	650,886,325.52	1,391,079,789.17	4,420,756,719.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	159,702,992.24	159,702,992.24
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,378,790,604.74	650,886,325.52	1,550,782,781.41	4,580,459,711.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(159,702,992.24)	-	(159,702,992.24)
Тайлант үеийн үр дүн	-	-	786,026,763.30	786,026,763.30
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,378,790,604.74	491,183,333.28	2,336,809,544.71	5,206,783,482.73

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,883,847,000.00	1,856,625,926.04	27,221,073.96	98.56
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,883,847,000.00	1,856,625,926.04	27,221,073.96	98.56
132001	Орон нутгийн төсвөөс	1,883,847,000.00	1,856,625,926.04	27,221,073.96	98.56
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,883,847,000.00	1,856,625,926.04	27,221,073.96	98.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,883,847,000.00	1,856,625,926.04	27,221,073.96	98.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,863,610,700.00	1,836,389,626.04	27,221,073.96	98.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,806,000.00	14,430,861.40	2,375,138.60	85.87
210301	Гэрэл, цахилгаан	7,320,000.00	5,640,501.40	1,679,498.60	77.06
210302	Түлш, халаалт	7,440,000.00	7,440,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,046,000.00	1,350,360.00	695,640.00	66.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,651,804,700.00	1,641,961,505.26	9,843,194.74	99.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,651,804,700.00	1,641,961,505.26	9,843,194.74	99.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,000,000.00	179,997,259.38	15,002,740.62	92.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,000,000.00	179,997,259.38	15,002,740.62	92.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,236,300.00	20,236,300.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,236,300.00	20,236,300.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,236,300.00	20,236,300.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 987,523.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,830.7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 20,731.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын зардал, 44,339.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 12,919.4 мянган төгрөгийн түлш шатах тослох материалын зардал, 19,951.6 мянган төгрөгийн барилгын засварын материалыг тус тус бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 879,353.9 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан.

Улсын төсвийн хөрөнгөөр 7,397.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэлд тусгах шийдвэргүй хөрөнгө орлогод бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 18,631.2 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 945 ширхэг 50,915.4 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

“төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

3. Зардлын дансны асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд санхүүгийн үр дүнгийн тайланд 124,280.1 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 102,599.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 21,680.9 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв, гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө аккруэл сууриар хөтлөх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,830.7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 20,731.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын зардал, 44,339.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 12,919.4 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг зардал, 19,951.6 мянган төгрөгийн барилгын засварын материалыг тус тус бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан.	1	100,772.2			1	100,772.2	1	100,772.2		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд 879,353.9 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан.	1	879,533.9			1	879,533.9	1	879,533.9		
3	Улсын төсвийн хөрөнгөөр 7.397.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэлд тусгах шийдвэргүй хөрөнгө орлогод бүртгэсэн.	1	7,397.7			1	7,397.7	1	7,397.7		
	Дүн	3	987,523.8			3	987,523.8	3	987,523.8		

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 945 ширхэг 50,915.4 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1						1					
3	Тайлант хугацаанд санхүүгийн үр дүнгийн тайланд 124,280.1 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 102,599.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 21,680.9 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан.	1						1					
	Дүн	3						3					

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 131 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 29 мэдээлэл, байршуулаагүй 11 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,883,753.3 мянган төгрөгийн 36 гүйлгээ, зарлагын 335,532.3 мянган төгрөгийн 12 гүйлгээ хугацаа хоцорч, зарлагын 4,790.3 мянган төгрөгийн 3 гүйлгээ байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	2,262,075.9					1	2,262,075.9
Дүн	1	2,262,075.9					1	2,262,075.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	2,262,075.9					1	2,262,075.9

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn